

2024 оны 11 сарын 27 ны өдөр

№ 30

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.17 дахь заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Одгэрэл/-д, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл хариуцсан захирал /Д.Баярбат/ нарт тус тус үүрэг болгосугай.
3. Хөтөлбөрийг шинэчлэн баталсантай холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 24-ны өдрийн 06 тоот тогтоолын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр” -ийг хүчингүйд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ





МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ДОТООД ХЯНАЛТЫН БОЛОН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр” /цаашид “Хөтөлбөр” гэх/-ийн зорилго нь Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх /цаашид “МУТС” гэх/-тэй тэмцэх тухай хууль, “Сэндли ББСБ” ХК /цаашид “ББСБ” гэх/-ийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журмын хэрэгжилтийг хангах, банк бусаар дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд эрсдэлийг тодорхойлох, харилцагчид үнэлгээ өгөх, түүнд үндэслэн эрсдэлийн түвшингээр ангилах, удирдах, хянахад оршино.
- 1.2 Хөтөлбөрт хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 1.2.1 “**ФАТФ**” гэж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх дэлхий нийтийн санхүүгийн системийг хамгаалах бодлогыг боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын, хараат бус бүлэг.
 - 1.2.2 “**Эцсийн өмчлөгч**” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-т заасныг;
 - 1.2.3 “**Комплаенсийн эрсдэл**” гэж хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллаагүйн улмаас ББСБ хуулийн хариуцлага, эрх бүхий байгууллагын торгууль шийтгэл хүлээх, санхүүгийн бодит алдагдалд орох, нэр хүндийн эрсдэл үүсэхийг;
 - 1.2.4 “**Нэр хүндийн эрсдэл**” гэж хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагын стандарт, шаардлага ББСБ-ын дүрэм, журмыг дагаж мөрдөөгүйгээс олон нийтэд ББСБ-ын тухай сөрөг мэдээлэл тархах, нэр хүнд унахад хүргэх эрсдэл;
 - 1.2.5 “**Хууль, эрх зүйн эрсдэл**” гэж холбогдох, хууль, дүрэм, журам болон эрх бүхий байгууллагын стандарт, шаардлагын хэрэгжилтийг хангаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүсэх эрсдэл;
 - 1.2.6 “**Санхүүгийн алдагдалд орох эрсдэл**” гэж дагаж мөрдөх хэм хэмжээг хэрэгжүүлээгүйгээс торгууль, шийтгэл хүлээх, санхүүгийн алдагдалд орох эрсдэл;
 - 1.2.7 “**Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэл**” гэж байгаль, орчны хүчин зүйл, уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдэл, нийгмийн харилцаанаас үүсэх эрсдэл болон компанийн засаглалын асуудлаас иргэн, хуулийн этгээдэд үүсэх эрсдэл;
 - 1.2.8 “**МУТС-ээс үүсэх эрсдэл**” гэж харилцагч эсвэл ББСБ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдэл гаргаснаар ББСБ-д учирч болох хохирол, сөрөг үр нөлөөг;

- 1.2.9 “Бизнесст суурилсан мөнгө угаах эрсдэл” гэж ББСБ-ын харилцагчдад санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг хүргэж буй арга хэлбэр болон харилцагчдад үйлчилгээ үзүүлж буй ББСБ-ын бүс нутаг зэргээс хамаарч үүсэх эрсдэлийг:
- 1.2.10 “Харилцаанд суурилсан харилцагчийн мөнгө угаах эрсдэл” гэж харилцагчийн ашиглаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг ашиглаж буй арга хэлбэр, харилцагчийн үйл ажиллагаа явуулж буй эсвэл ажил эрхэлж буй бүс нутаг болон бусад харилцагчийн хувийн эрсдэлийн үзүүлэлтээс хамаарч үүсэх эрсдэлийг:
- 1.2.11 “Харилцагчийн хувийн эрсдэлийн үзүүлэлт” гэж харилцагч байгууллагын хувьд байгууллагын төрөл, бизнесийн үйл ажиллагааны чиглэл, харилцагчийн иргэний хувьд нас, боловсрол, бизнесийн үйл ажиллагааны чиглэл зэргийг.
- 1.2.12 “Улс төрд нөлөө бүхий этгээд” гэж “Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 20.2-т заасан этгээд эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;

Хоёр. Харилцагчийг таниж мэдэх хөтөлбөр

- 2.1 Харилцагчийг таниж мэдэх: Банк бус нь зохистой итгэл үнэмшилтэй болохын тулд хувийн мэдээллийг цуглуулах, баталгаажуулахдаа баримтын болон баримтын бус аргыг ашиглаж болно. Баримтын бус аргыг ашиглах тохиолдолд заавал баримтын аргатай хослуулан ашиглана.
- 2.2 Харилцагчаар бүртгэхдээ:

Иргэнд тавигдах гол шаардлага:

- Харилцагчийн овог, нэр
- Төрсөн огноо
- Регистерийн дугаар,
- Иргэний бүртгэлийн дугаар
- Байнга оршин суух хаяг, утасны дугаар
- Ажлын тодорхойлолт эсвэл бизнесийн талаарх мэдээлэл (бизнесийн төрөл, хамрах хүрээ, албан хаяг, харилцагчийн албан тушаал, харилцагчийн нэрийн өмнөөс ажиллаж байгаа эсэх гэх мэт)
- Зээл олгох тохиолдолд ЗҮАЖ-д заасан өргөдлийн маягтыг бөглөж хувийн хэрэгт хавсаргана.
- Иргэний үнэмлэхний эсвэл паспортын хуулбар (хэрэв шуудангаар явуулах бол Иргэний үнэмлэхний эсвэл паспортын нотариатаар баталгаажуулсан хуулбар)

Хуулийн этгээдэд тавигдах гол шаардлага:

- Нэр
- Албан хаяг, утасны дугаар
- Улсын бүртгэлийн дугаар, регистерийн дугаар
- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (хэрэв шуудангаар явуулах бол бичиг баримтын нотариатаар баталгаажуулсан хуулбар, удирдлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл)

- Хувьцаа эзэмшигчид
- Бизнесийн төрөл
- Эзэмшлийн бүтэц, удирдлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл
- Эцсийн өмчлөгчийн мэдээлэл
- Хуулийн зохицуулалтын хувьд холбоотой талуудын талаарх мэдээлэл
- Зээл олгох тохиолдолд ЗҮАЖ-д заасан өргөдлийн маягтыг бөглөж хувийн хэрэгт хавсаргана.

Эцсийн өмчлөгчийн талаар:

- Эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс данс нээж, гүйлгээ хийж байгаа эсэхийг мэдэх, ойлгох зорилгоор тухайн бизнесийн харилцааны зорилго, гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээллийг тодруулах,
 - Харилцагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог, эцэг эхийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийн талаар болон харилцагчийн өмчлөл хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах,
- 2.3 Банк бус нь харилцагчийн мэдээллийг баримтын аргатай хослуулан баримтын бус аргаар баталгаажуулахдаа харилцагчийн холбоо барих, гишүүнээс авсан мэдээллийг олон нийтийн мэдээллийн сан эсхүл бусад олон нийтийн мэдээллийн эх сурвалж зэргээс авсан мэдээлэлтэй харьцуулах мөн лавлагааг бусад санхүүгийн тайлагналын байгууллагатай тулгах, санхүүгийн тайланг авах замаар холбогдох мэдээллийг баталгаажуулж болно.
- 2.4 Дараах шинж тэмдэг илэрсэн харилцагчийн гүйлгээг сэжиглэн эрсдэлийн үнэлгээ хийнэ.
- 2.4.1 Өөрийн нэр дээр тогтмол хийдэг гүйлгээ нь тухайн харилцагчийн ажил эрхлэлтийн байдалтай үл нийцэж байгаа,
 - 2.4.2 Өмнө хийж заншсан гүйлгээний давтамж, төрөл, хэмжээ тодорхойгүй шалтгаанаар огцом өөрчлөгдсөн,
 - 2.4.3 Гүйлгээг бэлэн мөнгөний гүйлгээний тайлангын хэмжээнд хүргэхээс илт зайлсхийж байгаа,
 - 2.4.4 Олон хүн хангалттай мэдээлэл өгөлгүйгээр нэг дансанд бага бус дүнтэй мөнгө хийж байгаа,
 - 2.4.5 Харилцагч гүйлгээ хурдан хийхийг шаардах, учир шалтгаангүй яарч сандрах, уцаарлах,
 - 2.4.6 Харилцагч гүйлгээ хийх бүрдээ зөвхөн бичиг баримтын бүдэг, гаргац муутай хуулбар ашиглах,
 - 2.4.7 Хууль, журамд заасан мэдээлэл өгөхөөс тогтмол татгалздаг/илт дургүйцдэг,
 - 2.4.8 Хуурамч /хуурамч гэж сэжиглэх үндэслэлтэй/ бичиг баримтад үндэслэн гүйлгээ хийж байгаа,
 - 2.4.9 Харилцагч өөрийн нэр дээр богино хугацааны дотор олон ижил төрлийн данс нээлгэх,
 - 2.4.10 Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан нэгж болон хэрэгжилт харицсан ажилтан нь үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд.
- 2.5 Өндөр эрсдэлтэй харилцагчийг таниж мэдэх
- 2.5.1 Улс төрд нөлөө бүхий этгээд болон Улс төрийн намын удирдлагад байсан, байгаа хувь хүн, олон улсын байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн,

захирал, орлогч захирал байсан, байгаа хувь хүнийг улс төрд нөлөө бүхий этгээдтэй адил авч үзэн өндөр эрсдэлтэй харилцагчид тооцно.

2.5.2 Харилцагч иргэн, хуулийн этгээдийн нэр нь НҮБ, ФАТФ болон дотоодын эрх бүхий байгууллагаас гаргасан хар жагсаалтад орсон улсын иргэн, холбогдох жагсаалтын нэртэй таарсан тохиолдолд бүртгэл, гүйлгээг түтгэлзүүлж, нэн даруй “Сэндли ББСБ” ХК-ны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журмын дагуу арга хэмжээг авч ажиллана.

2.5.3 Хөтөлбөрийн гурав, дөрөвдүгээр бүлэгт заасан үнэлгээний дагуу өндөр, ноцтой эрсдэлтэй гэж үнэлэгдсэн харилцагчийг өндөр эрсдэлтэй харилцагчид тооцно.

Гурав. Комплаенсийн эрсдэл

3.1 ББСБ-ын “Комплаенсийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангах үүднээс энэхүү хөтөлбөрийн дагуу комплаенсийн эрсдэлийг тодорхойлно.

3.2 **Нэр хүндийн эрсдэл** – ББСБ-ын үйл ажиллагаанд дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэр хүндийн эрсдэл үүссэн гэж үзэх ба тухай бүрт ББСБ-ын Маркетингийн үйл ажиллагаа хариуцсан нэгж шаардлагатай арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

3.2.1 Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр ББСБ-ын тухай сөрөг мэдээлэл цацагдах:

3.2.2 Харилцагчдын ББСБ-д итгэх итгэл алдарч нийгэмд ББСБ-ын талаар сөрөг хандлага гаргах:

3.2.3 Харилцагчдад бүтээгдэхүүн, үйлчилгээг хангалттай хэмжээнд хүргэж чадахгүй байх:

3.2.4 Бусад.

3.3 **Хууль, эрх зүйн эрсдэл** – ББСБ-ын үйл ажиллагаанд дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд хууль, эрх зүйн эрсдэл үүссэн гэж үзнэ. Үүнд:

3.3.1 Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хөдөлмөрийн маргаан үүсэх /Улсын тэмдэгтийн хураамж, нотариатын зардал, шүүхийн шийдвэрээр нэхэмжлэгчид олгосон ажилгүй байх хугацааны цалин хөлстэй тэнцэх олговор, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр бичсэн нөхөн бичилт гэх мэт/;

3.3.2 Дээрх маргаантай холбогдуулан нэхэмжлэгчийн албан тушаалд томилогдон ажилласан ажилтны цалингийн зардал, нэмэлт зардал гаргах:

3.3.3 Хамтран ажиллагч байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас шүүхэд хариуцагчаар татагдах:

3.3.4 Эрх бүхий байгууллагын шалгалтаар холбогдох хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллаагүйн улмаас торгууль, шийтгэл хүлээх.

3.3.5 Аргачлалын 2.3.1-2.3.3 дахь заалтуудад тусгагдсан эрсдэл учирсан тохиолдолд Хууль эрх зүйн асуудал хариуцсан нэгж болон комплаенсийн ажилтан, 2.3.4 дэх заалтад тусгагдсан эрсдэл учирсан тохиолдолд холбогдох газар, хэлтэс, алба нь үйл ажиллагааны чиглэлээс хамаарч эрсдэлийг хохирол багатайгаар даван туулах арга хэмжээг авч ажиллана.

- 3.3.6 ББСБ-д хууль, эрх зүйн эрсдэл үүсч буй эсэхийг үнэлэхдээ Комплаенсийн ажилтан нь Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан нэгжтэй хамтран шаардлагатай судалгаа, шинжилгээнд үндэслэн жилд нэг удаа үнэлгээг хийнэ. Үнэлгээг дараа оны эхний сард багтаан гүйцэтгэнэ.
- 3.4 **Санхүүгийн алдагдалд орох эрсдэл** - ББСБ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг хангаагүйгээс Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулж, санхүүгийн алдагдалд орох эрсдэл үүсч болзошгүй бөгөөд эрсдэл үүссэн тохиолдолд Комплаенсийн үйл ажиллагаа хариуцсан нэгж холбогдох газар, хэлтэс, албатай хамтран эрсдэл бууруулах, цаашид урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.4.1 ББСБ-ын олгосон зээл, валют арилжаа болон ББСБ-ын бусад үйл ажиллагаанаас хамаарч санхүүгийн бодит алдагдалд орох эрсдэлийг Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан нэгж үнэлж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.
- 3.5 **Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэл** – Тус эрсдэлийн үнэлгээг ББСБ-ын байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогын дагуу Эрсдэл хяналт шалгалт хариуцсан нэгж нь холбогдох хариуцсан нэгжтэй хамтран тодорхойлох, үнэлэх, бууруулах арга хэмжээг авч ажиллана.
- 3.6 Энэхүү аргачлалын 2.2-2.5 дахь заалтуудад тусгагдсан эрсдэл үүссэн тохиолдолд Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан нэгж, комплаенсийн ажилтан чиг үүргийн дагуу шаардлагатай үнэлгээг хийж, эрсдэлийг хаах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Дөрөв. МУТС эрсдэлийг үнэлэх

- 4.1 ББСБ нь МУТС-ээс урьдчилан сэргийлэх үүднээс энэхүү аргачлалын 4.3-4.5 дахь заалтуудын дагуу МУТС эрсдэлийг тодорхойлж, үнэлнэ.
- 4.2 ББСБ нь МУТС эрсдэлийн үнэлгээг хийхдээ бизнест суурилсан эрсдэл, харилцаанд суурилсан харилцагчийн эрсдэл гэсэн 2 хэлбэрээр МУТС эрсдэлийн үнэлгээг хийнэ.
- 4.3 Бизнест суурилсан МУТС эрсдэлийн үнэлгээг хийхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:
- 4.3.1 ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарч үүсэх эрсдэл – ББСБ-ын үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглаж МУТС эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх үүднээс ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтыг үүсгэж, МУТС магадлал, нөлөөллийг харгалзан үзэж эрсдэлийн үнэлгээг хийнэ.
- 4.3.2 Сувгийн эрсдэл /ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл/ - Hi-ray, картын төлбөр тооцоо, ашиглалт зэрэгтэй адил төлбөр тооцооны шинэ аргууд нэвтэрсэн тохиолдолд МУТС магадлал, нөлөөллийг харгалзан үзэж эрсдэлийн үнэлгээг хийнэ.
- 4.3.3 ББСБ эрсдэлийн үнэлгээг 4.3.1, 4.3.2 дахь заалтуудын дагуу жилд нэг удаа хийнэ. Хэрэв жилд нэг удаа хийсэн үнэлгээнээс хойш шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрэх түүнийг харилцагчдад хүргэх шинэ суваг нэвтрээгүй тохиолдолд үнэлгээг дахин хийхгүй байж болно.

- 4.3.4 ББСБ-ын бүс нутгийн байршлаас хамаарч үүсэх эрсдэл – Тус эрсдэлийн үнэлгээг жилд нэг удаа хийх бөгөөд үнэлгээ хийснээс хойш ББСБ-ын шинэ нэгж байгуулагдаагүй тохиолдолд үнэлгээг дахин хийхгүй байж болно. Тус эрсдэлийг үнэлэхдээ ББСБ-ын нэгжийн дараах хүчин зүйлсийг үндэслэн эрсдэлийг үнэлнэ. Үүнд:
- 4.3.4.1 Улаанбаатар хот болон орон нутгийн итгэлцэл өндөртэй нэгж:
 - 4.3.4.2 Улаанбаатар хот болон орон нутгийн гүйлгээний тоо ихтэй нэгж:
 - 4.3.4.3 Хил залгаа орнууд /ОХУ, Хятад/-тай ойролцоо нэгж.
- 4.4 Харилцаанд суурилсан харилцагчийн МУТС эрсдэлийн үнэлгээг хийхдээ дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:
- 4.4.1 Харилцагчийн хувийн эрсдэлийн үзүүлэлт:
 - 4.4.2 Харилцагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах байдлаас үүсэх эрсдэл:
 - 4.4.3 Харилцагчийн бүс нутгийн /газар зүйн байршил, улс орны/ эрсдэл:
 - 4.4.4 Харилцагчийн ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг авч буй хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл:
 - 4.4.5 Харилцагчийн бизнесийн харилцааны зорилгоос үүсэх эрсдэл.
- 4.5 ББСБ шинээр корреспондент харилцаа тогтоохоор гадаадын банктай хүсэлт гаргах тохиолдолд Комплаенсийн ажилтан нь Гуйвуулга хариуцсан захиралтай хамтран дүгнэлт гаргах бөгөөд дараах тохиолдолд эрсдэлтэй гэж үзэж харилцаа тогтоохгүй, данс нээхгүй. Үүнд:
- 4.5.1 Олон нийтэд нээлттэй мэдээлэл болон интернет дээрх нэр хүндийн талаарх мэдээлэл сөрөг:
 - 4.5.2 Өмнө нь МУТС-тэй холбоотой шалгагдаж, торгуулж байсан:
 - 4.5.3 Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас гаргасан 40 зөвлөмжийг хангалттай хэрэгжүүлдэггүй:
 - 4.5.4 Гадаад гүйлгээний хяналт сул:
 - 4.5.5 Халхавч банк эсвэл халхавч банктай харилцаатай.

Тав. Үнэлгээнд ашиглах шалгуур үзүүлэлт, эрсдэлийн түвшин

5.1 Бизнес суурилсан МУТС эрсдэлийн үнэлгээ:

- 5.1.1 МУТС магадлал, нөлөөллийг тооцохдоо Комплаенсийн ажилтан тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ, сувгийн талаарх судалгаа, тайланд үндэслэн дараах хүснэгтийн дагуу эрсдэлийн түвшинг тодорхойлно.

Үнэлгээ	Магадлал	Нөлөөлөл
1	Эрсдэл үүсэх магадлал өндөр	Эрсдэлийн нөлөөлөл өндөр
2	Эрсдэл үүсэх магадлал дунд зэрэг	Эрсдэлийн нөлөөлөл дунд зэрэг
3	Эрсдэл үүсэх магадлал бага	Эрсдэлийн нөлөөлөл бага

5.1.2 Аргачлалын 4.1.1 дэх заалтын дагуу тогтоосон эрсдэлийн магадлал, нөлөөлөлд тулгуурлан дараах матрицын дагуу эрсдэлийн түвшинг тогтооно.

МАГАДЛАЛ	Өндөр	Дунд	Өндөр	Өндөр
	Дунд	Бага	Дунд	Өндөр
	Бага	Бага	Бага	Дунд
		<i>Бага</i>	<i>Дунд</i>	<i>Өндөр</i>

НӨЛӨӨЛӨЛ

5.1.3 ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарч үүсэх эрсдэлийг тооцох:

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Магадлал	Нөлөөлөл	Эрсдэлийн түвшин
1	Итгэлцэлийн үйлчилгээ			
2	Гадаад төлбөр тооцооны үйлчилгээ			
3	Бүх төрлийн зээлийн үйлчилгээ			
4	Валют арилжаа			
5	Баталгаа батлан даалт			
...				

5.1.4 Сувгийн эрсдэл /ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл/-ийг тооцох:

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх суваг	Магадлал	Нөлөөлөл	Эрсдэлийн түвшин
1	Hi-pay апплейкшн			
2	Банкны карт			
3	Сэндли апплейкшн /зээл/			
4	Сэндли апплейкшн /гуйвуулга/			
...				

5.1.5 Аргачлалын 5.1.3 болон 5.1.4 дэх заалтын дагуу эрсдэлийг үнэлэхдээ тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглаж буй харилцагчдын тоог ББСБ-ын нийт харилцагчдын тоонд харьцуулах замаар үнэлнэ.

5.1.6 ББСБ-ын бүс нутгийн байршлаас хамаарч үүсэх эрсдэл:

№	ББСБ-ын нэгж	Магадлал	Нөлөөлөл	Эрсдэлийн түвшин
Улаанбаатар хот болон орон нутгийн итгэлцэл өндөртэй нэгж				
1				
2				
Улаанбаатар хот болон орон нутгийн гүйлгээний тоо ихтэй нэгж:				
1				
2				
Хил залгаа орнууд /ОХУ, Хятад/-тай ойролцоо нэгж				
1				
2				

5.1.7 Гүйлгээний тоо ихтэй нэгж-ийн жагсаалтыг гаргахдаа сард хийгдэж буй гүйлгээний дундаж тоог ББСБ-ын нэгж тус бүрээр, итгэлцэл өндөртэй нэгж-ийг тодорхойлохдоо сар бүрийн итгэлцэлийн дундажын мэдээ, тайланг ББСБ-ын нэгж тус бүрээр гаргана.

5.1.8 Тухайн мэдээ, тайланд үндэслэн нийт нэгжийн гүйлгээний тоог интервалаар хувааж, хамгийн их хувийг эзэлж байгаа интервалаас давсан гүйлгээтэй нэгжийг, нийт нэгжийн итгэлцэлийн хэмжээг интервалаар хувааж, хамгийн их хувийг эзэлж байгаа интервалаас давсан итгэлцэлтэй нэгжийг тус тус 5.1.6-д заасны дагуу эрсдэлийг үнэлнэ.

5.1.9 Хил залгаа орнуудтай ойролцоо нэгжийн эрсдэлийн түвшинг тогтооходоо нэгжүүдийн жагсаалтыг гаргаж, түүнээс гүйлгээний тоо, валют арилжааны тоо болон итгэлцэл өндөртэй нэгжүүдийг давхар шүүж, эрсдэлийн түвшинг тогтооно.

5.2 Харилцаанд суурилсан харилцагчийн МУТС эрсдэлийн үнэлгээ:

5.2.1 Тус эрсдэлийг үнэлэхдээ харилцагч иргэн, харилцагч байгууллагаар ялган 5.2.5-5.2.9 дэх заалтын дагуу дэлгэрүүлэн үнэлэх ба идэвхтэй төлөвтэй байгууллага болон 18 нас хүрсэн иргэнийг үнэлгээнд хамруулна.

5.2.2 ББСБ-д бүртгэлтэй харилцагчийг энэхүү аргачлалын хавсралт 1-ийн дагуу, шинээр бүртгүүлж буй харилцагчийг хавсралт 2-ын дагуу Core программ дээр үнэлнэ.

5.2.3 ББСБ-д бүртгэлтэй харилцагчийг хамгийн багадаа жилд 1 удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр үнэлнэ. Шинээр бүртгүүлж буй харилцагчийг бүртгэл үүссэн өдрийн дараа программд автоматаар үнэлнэ.

5.2.4 Харилцагчийн МУТС эрсдэлийг үнэлэхдээ үзүүлэлт бүрт 1-100 хооронд оноо өгөх ба сонгосон үзүүлэлтийн эрсдэлийн түвшинг илэрхийлэх итгэлцүүрээр жигнэж тооцсон онооны нийлбэр 100 байна.

5.2.5 Шалгуур үзүүлэлт, тэдгээрт тохирох итгэлцүүрийг ашиглан хийсэн үнэлгээний нийлбэр дүнгээс хамаарч эрсдэлийн түвшинг дараах байдлаар 3 ангилна. Үүнд:

Коэффициент	Эрсдэл
0-30	БАГА /LOW/
31-60	ДУНД /MEDIUM/
61-100	ӨНДӨР /HIGH/

5.2.6 Харилцагчийн хувийн эрсдэлийн үзүүлэлт:

5.2.6.1 Байгууллагын төрөл:

- Төрийн өмчит байгууллага
- Хувийн өмчит байгууллага
- Холимог өмчтэй /Гадаадтай хамтарсан/
- Төрийн бус байгууллага
- Нам олон нийтийн байгууллага
- Шашины байгууллага
- Олон улсын байгууллага (Үнэлгээний матриц 1. Байгууллагын төрөл хэсгээс харгалзах оноог харах)

5.2.6.2 Нас:

- 18-23
- 24-30
- 31-40
- 41-ээс дээш (Үнэлгээний матриц 3. Нас хэсгээс харгалзах оноог харах)

5.2.6.3 Боловсрол:

- Бүрэн бус дунд
- Бүрэн дунд
- Дээд (Үнэлгээний матриц 4. Боловсрол хэсгээс харгалзах оноог харах)

5.2.6.4 Бизнесийн үйл ажиллагааны чиглэл:

- Зэвсэг, хар тамхи, мансууруулах төрлийн бодис үйлдвэрлэх, худалдах, зуучлах
- Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулах, зуучлах
- Үнэт цаасны болон валютын арилжаа эрхлэх
- Казино мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа
- Уул уурхай, олборлолт
- Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- Ашгийн бус шашны болон буяны үйл ажиллагаа
- Өмгөөлөл, нотариат, нягтлан бодох бүртгэл/нягтлан бодогч/ болон хууль эрх зүйн болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх
- Улс дамнасан сүлжээний бизнес эрхлэх
- Аялал жуулчлал

- Үнэт эдлэл, эртний эд зүйлсийн худалдаа эрхлэх
- Гадаад худалдаа
- Банк санхүү, хадгаламж зээлийн үйлчилгээ
- Даатгал, сангийн үйл ажиллагаа
- Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ
- Олон Улсын байгууллагын үйл ажиллагаа
- Улс төрийн нам эвсэл, холбоо, улс төрд нөлөө бүхий албан тушаал эрхлэх. (Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-д заасан этгээдийг Улс төрд нөлөө бүхий этгээд гэж үзнэ.)
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч иргэн, хуулийн этгээд

Дээрх үйл ажиллагаа эрхэлдэг бол өндөр эрсдэлтэйд, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг бол дунд эрсдэлтэйд, дээр огт дурдагдаагүй үйл ажиллагааг бага буюу эрсдэлгүй гэж үзнэ. (*Үнэлгээний матриц 5. Бизнесийн үйл ажиллагаа хэсгээс харах*)

5.2.7 Харилцагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах байдлаас үүсэх эрсдэл:

Харилцагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ, зээлийн хугацаа хэтрэлт, гадаад болон дотоод, гүйлгээний хэмжээ, огцом өөрчлөлттэй, сэжигтэй гүйлгээ хийгдсэн эсэх зэргийг үндэслэх үнэлгээг хийнэ.

5.2.7.1 Харилцагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ:

- Улс хоорондын мөнгөн гуйвуулга, шилжүүлэг;
- Гадаад валют, үнэт металлын арилжаа;
- Хүлээн авагчийн эсхүл шилжүүлэгчийн нэр тодорхойгүй гүйлгээ;
- Хамааралгүй гуравдагч этгээдийг оролцуулан хийгдсэн төлбөр тооцоо болон бусад гүйлгээ;
- Хэвийн бусаар /огцом/ өөрчлөгдсөн дүнтэй гүйлгээ
- Дансны зориулалт өөрчлөгдсөн гүйлгээ. (Үнэлгээний матриц 10. Бүтээгдэхүүн, үйлчилгээ хэсгээс харах)

5.2.7.2 Зээлийн төрлөөс хамаарахгүйгээр зээлийн эргэн төлөлт хэвийн төлөгдсөн эсэхийг дараах байдлаар 5 ангилна.

- 361 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн;
- 181-360 хоног хугацаа хэтэрсэн;
- 91-180 хоног хугацаа хэтэрсэн;
- 90 хоног хугацаа хэтэрсэн;
- Хугацаандаа тогтмол төлөгдөж байсан (Үнэлгээний матриц 6. Зээлийн түүх хэсгээс харах);

5.2.7.3 Гүйлгээний эрсдэлийг үнэлэхдээ харилцагчийн жилийн турш хийсэн гүйлгээний дундаж мөнгөн дүнг гаргаж, дараах байдлаар 4 ангилна.

- 200,000,001 төгрөгөөс дээш;
- 100,000,001-200,000,000 төгрөгөөс хүртэл;
- 20,000,001-100,000,000 төгрөгөөс хүртэл;
- 20,000,000 төгрөг хүртэл. (Үнэлгээний матриц 7, 8, 9 дүгээр хэсгээс харах)

5.2.8 Харилцагчийн бүс нутгийн /газар зүйн байршил, улс орны/ эрсдэл:

Тус эрсдэлийг үнэлэхдээ дараах 3 төрлөөр ангилан үнэлнэ. Үүнд:

5.2.8.1 Тухайн харилцагч нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан террорист гэж зарлагдсан этгээдийн жагсаалт, АНУ, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Европын холбоо, бусад олон улсын эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад багтсан эсэх (Үнэлгээний матриц 11. Газар зүйн байршил хэсгээс харах);

5.2.8.2 Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас МУТС-тэй тэмцэх тогтолцоо нь хангалтгүй гэж тодорхойлогдсон улс орон болон терроризмын индекс өндөртэй улс орны харьяалалтай харилцагч эсэх. (Үнэлгээний матриц 11. Газар зүйн байршил хэсгээс харах);

5.2.8.3 Тухайн харилцагчийн үйл ажиллагаа явуулж байгаа эсвэл ажил эрхэлж байгаа бүс нутгаар ангилан тус тус үнэлнэ. (Үнэлгээний матриц 12. Үйл ажиллагаа явуулж буй газар хэсгээс харах);

5.2.9 Харилцагчийн ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг авч буй хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл:

Тус эрсдэлийг үнэлэхдээ тухайн харилцагч нь бүтээгдэхүүн, үйлчилгээг зайнаас буюу ББСБ-ын цахим суваг /*Hi-ray апплейкин, Сэндли апплейкин*/ ашиглан үйлчлүүлж байгаа байдал эсвэл ББСБ-ын нэгжээр биечлэн үйлчлүүлсэн эсэхийг харгалзан үнэлнэ. (Үнэлгээний матриц 13. Бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх хэлбэр /суваг/ хэсгээс харах);

5.2.10 Харилцагчийн бизнесийн харилцааны зорилгоос үүсэх эрсдэл:

Бизнесийн харилцааг харилцагч данс нээлгэсэн, зээл авсан, итгэлцэл байршуулсан зэрэг санхүүгийн харилцаа тогтоосноос хойш өнгөрсөн хугацааг харгалзан үзэх буюу харилцагчаар бүртгэж, бүртгэл үүсгэсэн огноог үндэслэн үнэлгээ хийнэ. (Үнэлгээний матриц 2. Бизнесийн харилцаа хэсгээс харах);

Зургаа. Хяналт, тайлагнал

- 6.1 Комплаенс, МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс Комплаенсийн ажилтан энэхүү аргачлалын дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- 6.1.1 Өндөр гэж үнэлэгдсэн харилцагчийн гүйлгээнд тогтмол хяналт тавьж, сэжигтэй гүйлгээ илэрсэн тохиолдолд СМА-нд мэдээлэх;
 - 6.1.2 Өндөр гэж үнэлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх сувгаар дамжуулан хийсэн гүйлгээнд хяналт тавьж, сэжигтэй гүйлгээ илэрсэн тохиолдолд СМА-нд мэдээлэх;
 - 6.1.3 Өндөр гэж үнэлэгдсэн ББСБ-ын газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэлийг тодорхойлох, бууруулах;
- 6.2 Комплаенсийн ажилтан энэхүү аргачлалын дагуу хийсэн үнэлгээний үр дүнг Гүйцэтгэх захиралд танилцуулна.
- 6.3 Гүйцэтгэх захирлаас чиглэл өгсөн тохиолдолд үнэлгээний талаар танилцуулга бэлтгэн ББСБ-ын холбогдох хорооны хурлаар хэлэлцүүлж болно.
- 6.4 Эрсдэлийн үнэлгээ болон түүнд ашигласан мэдээллийг баримтжуулан тухай бүр шинэчлэн хадгалах бөгөөд дотоод хяналт шалгалт хариуцсан нэгжээс шаардсан үед гаргаж өгөхөд бэлэн байлгана.

о–оОо-о

*“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын
хөтөлбөр” -ийн ХАВСРАЛТ №01*

**Харилцагчийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн түвшинг үнэлэх
үнэлгээний матриц**

№	Хүчин зүйлс	Утга	Тооцоололд ашиглах үзүүлэлтийн сонголт		Хамаарах /Эрсдэл тооцох/ хувь	Харгал-зах оноо	Мэдээлэл Core програм-маас гарах эсэх
			Хувь хүн	Байгууллага			
Харилцагчийн эрсдлийн үзүүлэлт	1. Байгууллагын төрөл	Төрийн өмчит байгууллага Хувийн өмчит Хамтарсан холимог өмчтэй гадаадтай хамтарсан /өмчлөлийн хэлбэрээс хамаарна/ Төрийн бус байгууллага Нам, олон нийтийн байгууллага Шашины байгууллага Олон улсын байгууллага Дээрх ангилалд ороогүй бусад			25 50 75 100 100 100 100 0	5	Тийм
	2. Бизнесийн харилцаа /ББСБ-тай харьцсан хугацаа/	0-11 сар 1-3 жил 3-5 жил 5-с дээш жил			100 75 50 25	5	Тийм
	3. Нас	18-23 24-30 31-40 41-ээс дээш			50 100 75 25	2.5	Тийм
	4. Боловсролын зэрэг	Бүрэн бус дунд Бүрэн дунд Дээд Дээрх ангилалд ороогүй бусад			25 50 100 0	2.5	Тийм
	5. Бизнесийн үйл ажиллагааны чиглэл	Зэвсэг, хар тамхи, мансууруулах төрлийн бодис үйлдвэрлэх, худалдах, зуучлах Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулах, зуучлах Үнэт цаасны болон валютын арилжаа эрхлэх Казино мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа Уул уурхай, олборлолт Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ Ашгийн бус шашны болон буяны үйл ажиллагаа Өмгөөлөл, нотариат, нягтлан			100	15	Тийм

		<p>бодох бүртгэл/нягтлан бодогч/ болон хууль эрх зүйн болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, Улс дамнасан сүлжээний бизнес эрхлэх, Улс төрийн нам эвсэл, холбоо улс төрд нөлөө бүхий албан тушаал эрхлэх, Олон улсын байгууллагын үйл ажиллагаа</p> <p>Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх, крипто валютын арилжаа хийх Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ Банк санхүү, хадгаламж зээлийн үйлчилгээ Даатгал, сангийн үйл ажиллагаа Аялал жуулчлал Үнэт эдлэл, эртний эд зүйлсийн худалдаа</p> <p>Гадаа худалдаа Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл Өөрийн ББСБ-ын ажилтан Дээрх ангилалд ороогүй бусад</p>			75		
					50		
					0		
Бүтээгдэхүүний эрсдэлийн үзүүлэлт	6. Зээлийн түүх	Хугацаандаа тогтмол төлөгдөж байсан 90 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн буюу ангилал 2 91-180 хоног хугацаа хэтэрсэн буюу ангилал 3 181-360 хоног хэтэрсэн буюу ангилал 4 361-с дээш хоног хэтэрсэн буюу ангилал 5			0 25 50 75 100	5	Тийм/Зээлийн дэлгэрэнгүй тайлангаас авах/
	7. Гадаад гүйлгээ	20,000,000 төгрөг хүртэл 20,000,001 - 100,000,000 100,000,001 - 200,000,000 200,000,001 - төгрөгөөс дээш			25 50 75 100	10	Үгүй
	8. Бэлэн мөнгөний үйлчилгээ	20,000,000 төгрөг хүртэл 20,000,001 - 100,000,000 100,000,001 - 200,000,000 200,000,001 - төгрөгөөс дээш			25 50 75 100	15	Үгүй
	9. Бэлэн бус үйлчилгээ	20,000,000 төгрөг хүртэл 20,000,001 - 100,000,000 100,000,001 - 200,000,000 200,000,001 - төгрөгөөс дээш			25 50 75 100	10	Үгүй
	10. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, данс ашиглалт	Дараах төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг туйлын өндөр эрсдэлтэй гэж үзнэ. Үүнд: Улс хоорондын мөнгөн гуйвуулга, шилжүүлэг			100	10	Тийм

		<p>Чекийн үйлчилгээ</p> <p>Худалдааны санхүүжилтийн үйлчилгээ</p> <p>Гадаад валют, үнэт металлын арилжаа</p> <p>Хүлээн авагчийн эсхүл шилжүүлэгчийн нэр тодорхойгүй гүйлгээ болон бэлэн мөнгөний гүйлгээ</p> <p>Хамааралгүй гуравдагч этгээдийг оролцуулан хийгдсэн төлбөр тооцоо болон бусад гүйлгээ</p> <p>Хэвийн бусаар огцом өөрчлөгдсөн гүйлгээ</p> <p>Дансны зориулалт өөрчлөгдсөн гүйлгээ</p> <p>Дээрх төрлөөс бусад</p>			0		
Улс орны эрсдэлийн үзүүлэлт	11. Газар зүйн байршил	<p>Хориглосон бүс нутаг/ФАТФ-ын хар жагсаалт, террористуудын жагсаалтад орсон улс, хүн / Хил дамнасан бүс нутаг/монголоос бусад улс/ Тухайн бүс нутаг, дэвсгэрт/Монгол/</p>			100		
	12. Үйл ажиллагаа явуулж буй газар	<p>Монгол</p> <p>Бусад оронд</p> <p>Байгууллагын хувьд ХЭ, удирдлага, ЭӨ нь эрсдэлтэй бүс нутгийнх бол</p>			75	5	Тийм
	13. Бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга хэлбэр/суваг/	<p>ББСБ-ын цахим хэлбэрийн суваг/Hi-рау апп, Сэндли апп/ Салбар, нэгжээр биечлэн үйлчлүүлсэн болон бусад хэлбэрийн суваг.</p>			75	10	Тийм
					0		

*“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын
хөтөлбөр” -ийн ХАВСРАЛТ №02*

Шинэ харилцагчийн мөнгө угаах эрсдэлийг үнэлэх хүснэгт

Харилцагчийн нэр /шивэх/	Үзүүлэлт	Сегмент /иргэн эсвэл байгууллага гэж бичих/	Тооцох үзүүлэлт /будсан хэсэг/		Эрсдэл тооцох %	Бодох оноо	Тохирох үзүүлэлт байвал "1" байхгүй бол "0" гэсэн утга шивнэ.	Эрсдэлийн үнэлгээний тооцоолол
			Иргэн	Байгууллага				
А	Б	В	1	2	3	4	5	6
	1. Нас							
	18-23				50	2.5		
	24-30				100	2.5		
	31-40				75	2.5		
	41-ээс дээш				25	2.5		
	2. Боловсрол							
	Бүрэн бус дунд				25	2.5		
	Бүрэн дунд				50	2.5		
	Дээд				100	2.5		
	Дээрх ангилалд ороогүй				0	2.5		
	3. Байгууллагын төрөл							
	Төрийн өмчит байгууллага				25	5		
	Хувийн өмчит				50	5		
	Хамтарсан холимог өмчтэй гадаадтай хамтарсан, өмчлөлийн хэлбэрээс хамаарна.				75	5		
	Төрийн бус байгууллага				100	5		
	Нам, олон нийтийн байгууллага				100	5		
	Шашины байгууллага				100	5		
	Олон улсын байгууллага				100	5		
	Дээрх ангилалд ороогүй бусад				0	5		
	4. Үйл ажиллагааны чиглэл							
	Зэвсэг, хар тамхи, мансууруулах төрлийн бодис үйлдвэрлэх, худалдах, зуучлах				100	15		

Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулах, зуучлах			100	15		
Үнэт цаасны болон валютын арилжаа эрхлэх,			100	15		
Казино мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа,			100	15		
Уул уурхай, олборлолт			100	15		
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ,			100	15		
Ашгийн бус шашны болон буяны үйл ажиллагаа,			100	15		
Өмгөөлөл, нотариат, нягтлан бодох бүртгэл/нягтлан бодогч/ болон хууль зүйн болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх			100	15		
Улс дамнасан сүлжээний бизнес эрхлэх			100	15		
Улс төрийн нам эвсэл, холбоо улс төрд нөлөө бүхий албан тушаал эрхлэх			100	15		
Олон Улсын байгууллагын үйл ажиллагаа			100	15		
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх, крипто валют арилжаа хийх			100	15		
Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ			75	15		
Банк санхүү, хадгаламж зээлийн үйлчилгээ			75	15		
Даатгал, сангийн үйл ажиллагаа			75	15		
Аялал жуулчлал			75	15		
Үнэт эдлэл, эртний эд зүйлсийн худалдаа			75	15		
Гадаад худалдаа			75	15		
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл			50	15		
Дээрх ангилалд ороогүй бусад			0	15		
5. Бизнесийн харилцааны						

зорилго/бүтээгдэхүүн, үйлчилгээ/					
Улс хоорондын мөнгөн гуйвуулга, шилжүүлэг	100	2			
Чекийн үйлчилгээ	100	2			
Худалдааны санхүүжилтийн үйлчилгээ	100	2			
Гадаад валют, үнэт металлын арилжаа	100	2			
Дансны үйлчилгээ/гүйлгээ/	0	2			
Нi-рау апплейкшн /цахим үйлчилгээ/	75	2			
Дээрх төрлөөс бусад	0	0			
6. Газарзүйн байршил					
Хориглосон бүс нутаг /ФАТФ-ын хар жагсаалт, террористуудын жагсаалтад орсон улс, хүн/	100	10			
Хил дамнасан бүс нутаг/Монголоос бусад улс/	75	10			
Тухайн бүс нутаг, дэвсгэр/Монгол/	25	10			
7. Үйл ажиллагаа явуулж буй орон					
Монголд	25	5			
Бусад оронд	75	5			
Нийт оноо	X	X	X		0